



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Тусламж олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Монгол Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 4.5.4, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2015 оны 160 дугаар тушаалаар баталсан “Ажлын албаны хөдөлмөрийн дотоодын журам”-ын 8.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хяналт шалгалт зохицуулалтын газрын Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалах чиглэлийн ахлах хянан шалгагч Амарын Авир, Хяналт шалгалт зохицуулалтын газрын Банк бус санхүүгийн байгууллагын хяналтын чиглэлийн ахлах хянан шалгагч Сумъяагийн Чулуунтогтох нарын 50 насны ойд хүндэтгэл үзүүлж тус тус 300,000 /гурван зуун мянга/ төгрөгийн тусламж олгосугай.

2. Тусламж үзүүлэхэд шаардагдах 600,000 /зургаан зуун мянга/ төгрөгийг төсвийн холбогдох зардлаас гаргахыг Санхүү, хөрөнгө оруулалтын алба /Д.Хишигжаргал/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын газар /Б.Батзориг/-т даалгасугай.

ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ

